

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг:
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	“Уужим Алтай Аудит” ХХК-ны захирал: Б.Галымбек
	Утас: 99101563 Цахим хаяг:

нэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Н.ЭНЭБИШ ТАНАА

2024.02.23 № 306
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

Аудитын гол асуудал

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402375

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>107,529,166.04</u>	<u>145,723,093.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,740,404.00	41,535,202.90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38,740,404.00	41,535,202.90
3121	Төгрөг	38,740,404.00	41,535,202.90
31211	Төрийн сангийн харилцах	38,636,904.00	41,534,702.90
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	103,500.00	500.00
33	АВЛАГА	-	12,626,839.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	12,626,839.24
35	БАРАА МАТЕРИАЛ	68,788,762.04	91,561,051.56
354	Хангамжийн материал	68,788,762.04	91,561,051.56
35410	Бичиг хэргийн материал	108,900.00	597,800.00
35420	Аж ахуйн материал	28,274,309.00	45,034,654.00
35440	Түлш, шатах тослох материал	1,948,800.40	4,395,900.40
35460	Хүнсний материал	28,078,995.64	31,154,940.16
35470	Бусад хангамжийн материал	10,377,757.00	10,377,757.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>458,657,177.65</u>	<u>437,426,172.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	458,657,177.65	437,426,172.51
392	Биет хөрөнгө	450,601,177.65	427,946,933.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	490,620,717.00	490,620,717.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(49,856,361.12)	(75,146,171.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,174,500.00	16,410,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,158,129.55)	(8,776,012.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,973,196.00	13,973,196.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,194,644.68)	(11,177,195.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,400,000.00	8,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,400,000.00)	(8,400,000.00)
39217	Ном	2,041,900.00	2,041,900.00
393	Биет бус хөрөнгө	8,056,000.00	9,479,239.00
39301	Програм хангамж	275,000.00	1,698,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000.00)	(275,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,056,000.00	8,056,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>566,186,343.69</u>	<u>583,149,266.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,958,565.00</u>	<u>24,930,760.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,958,565.00	24,930,760.00
413	Өглөг	10,958,565.00	24,930,760.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	86,565.00	-

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4136	Бусад өглөг	10,872,000.00	24,930,760.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	10,872,000.00	24,930,760.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	555,227,778.69	558,218,506.21
51	Засгийн газрын хувь оролцоо	555,227,778.69	558,218,506.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	57,469,048.00	57,469,048.00
51101	Өмч: - төрийн	57,469,048.00	57,469,048.00
512	Хуримтлагдсан үр дүн	441,233,629.77	444,224,357.29
51210	Өмнөх үеийн үр дүн	441,233,629.77	441,233,629.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,990,727.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,525,100.92	56,525,100.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	566,186,343.69	583,149,266.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	596,724,960.00	608,047,839.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,605,760.00	16,779,239.00
120	Нийтлэг татварын бус орлого	114,605,760.00	16,779,239.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого о-Үндсэн хөрөнгө	114,605,760.00	5,779,239.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого о-Бараа материал	-	11,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	482,119,200.00	591,268,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	429,536,000.00	563,795,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	429,536,000.00	563,795,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,479,700.00	27,473,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,479,700.00	27,473,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	448,924,123.02	605,057,111.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,924,123.02	605,057,111.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,612,999.02	605,057,111.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,071,540.00	412,422,114.00
210101	Үндсэн цалин	263,682,355.00	313,636,867.74
210102	Нэмэгдэл	48,580,731.00	86,334,480.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	7,808,454.00	12,450,765.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,760,877.00	59,209,100.00
210201	Тэтгэврийн даатгал	23,737,077.00	40,262,700.00

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	2,273,200.00	4,737,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,531,300.00	3,789,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	670,900.00	947,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,548,400.00	9,473,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,657,811.00	36,581,100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,673,600.00	-
210302	Түлш, халаалт	28,984,211.00	36,581,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,840,845.00
210401	Бичиг хэрэг	-	59,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,781,845.00
2105	Нормативт зардал	41,306,465.60	52,752,853.48
210502	Хоол, хүнс	41,306,465.60	52,752,853.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	103,000.00
210604	Урсгал засвар	-	103,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	612,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	612,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,204,305.42	42,148,099.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,480,800.00	12,260,901.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	812,000.00	1,996,953.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,911,505.42	27,890,244.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	311,124.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	311,124.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	311,124.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>147,800,836.98</u>	<u>2,990,727.52</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>147,800,836.98</u>	<u>2,990,727.52</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>482,119,200.00</u>	<u>591,268,600.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>482,119,200.00</u>	<u>591,268,600.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	429,536,000.00	563,795,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	429,536,000.00	563,795,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,479,700.00	27,473,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,479,700.00	27,473,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>443,378,796.00</u>	<u>587,593,801.10</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>443,378,796.00</u>	<u>587,593,801.10</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>443,067,672.00</u>	<u>587,593,801.10</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,071,540.00	427,351,661.24

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

210101	Үндсэн цалин	263,682,355.00	289,050,610.84
210102	Нэмэгдэл	48,580,731.00	126,547,150.40
210104	Урамшуулал	7,808,454.00	11,753,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,654,400.00	59,209,100.00
210201	Тэтгэврийн даатгал	23,630,600.00	40,262,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,273,200.00	4,737,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,531,300.00	3,789,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	670,900.00	947,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,548,400.00	9,473,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,653,527.00	27,173,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,213,600.00	2,213,600.00
210302	Түлш, халаалт	19,439,927.00	24,960,000.00
2105	Нормативт зардал	56,028,805.00	55,534,595.00
210502	Хоол, хүнс	56,028,805.00	55,534,595.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	403,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	403,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,106,000.00	969,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,106,000.00	969,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,253,400.00	16,952,644.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,757,400.00	14,045,144.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,496,000.00	2,907,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	311,124.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	311,124.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	311,124.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>38,740,404.00</u>	<u>3,674,798.90</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	880,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	880,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	880,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	880,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(880,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	38,740,404.00	2,794,798.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		38,740,404.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,740,404.00	41,535,202.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	57,469,048.00	56,525,100.92	441,233,629.77	555,227,778.69

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,469,048.00	56,525,100.92	441,233,629.77	555,227,778.69
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,469,048.00	56,525,100.92	441,233,629.77	555,227,778.69
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	57,469,048.00	56,525,100.92	441,233,629.77	555,227,778.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,469,048.00	56,525,100.92	441,233,629.77	555,227,778.69
D08	Тайлант үеийн үр дүн			2,990,727.52	2,990,727.52
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,469,048.00	56,525,100.92	444,224,357.29	558,218,506.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,636,900.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	629,905,500.00	588,370,801.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	629,905,500.00	588,370,801.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	629,905,500.00	588,370,801.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	464,946,400.00	427,351,661.24
210101	Үндсэн цалин	302,871,500.00	289,050,610.84
210102	Нэмэгдэл	150,321,000.00	126,547,150.40
210104	Урамшуулал	11,753,900.00	11,753,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,333,900.00	59,209,100.00
210201	Тэтгэврийн даатгал	41,027,500.00	40,262,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,827,100.00	4,737,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,861,000.00	3,789,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	965,200.00	947,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,653,100.00	9,473,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,173,600.00	27,173,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,213,600.00	2,213,600.00
210302	Түлш, халаалт	24,960,000.00	24,960,000.00
2105	Нормативт зардал	58,318,300.00	55,534,595.00
210502	Хоол, хүнс	58,318,300.00	55,534,595.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	969,200.00	969,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	969,200.00	969,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,864,100.00	17,832,644.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,956,600.00	14,925,144.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,907,500.00	2,907,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	629,905,500.00	591,268,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	563,795,000.00	563,795,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	563,795,000.00	563,795,000.00

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,473,600.00	27,473,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	27,473,600.00	27,473,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,636,900.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,636,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		38,636,904.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		41,534,702.90
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	42
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	21	21
620003	Үйлчлэх ажилтан	17	17
620004	Гэрээт ажилтан	3	3
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	268	268
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	268	268
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	268	268
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42.00	42.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21.00	21.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103000.00
210604	Урсгал засвар	103000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	-103000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	103500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Цэцэрлэгийн гадна, дотор өнгө үзэмжийг сайжруулж, эцэг, эх, хүүхэд, багш, ажиллагчдыг уриалсан, сэтгэл зүрхийг нь татсан тохилог, шинэчилсэн тав тухтай, саруул, цэвэрхэн сургалтын таатай орчноор хангах” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, эцэг, эхтэй хамтран ажиллах, хамтаараа шийдлийг олох, баг хамт олноороо удаа дараа ярилцаж зөвшилцөх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй ба тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.9 сая төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,740.40	41,535.20	2,794.80
Авлага	0.00	12,626.84	12,626.84
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	68,788.76	91,561.05	22,772.29
Үндсэн хөрөнгө	458,657.18	437,426.17	-21,231.01
Нийт хөрөнгө	566,186.34	583,149.27	16,962.92
Өр төлбөр	10,958.57	24,930.76	13,972.20
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	555,227.78	558,218.51	2,990.73
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	566,186.34	583,149.27	16,962.92

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 41.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 22.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 106.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 11.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 94.1 сая төгрөгийг зарцуулсан холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 21.2 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 0.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 5.8 сая төгрөгийн хөрөнгө орлогод авч, үндсэн хөрөнгөнд 27.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 2.9 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны батлагдсан төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 563.8 сая, орон нутгийн төсвөөс 27.5 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 38.6 сая, нийт зарлагыг 629.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 629.9 сая төгрөг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 257.1 сая , орон нутгийн төсвөөс 12.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588.4 сая төгрөг буюу 93.4 хувьтай байна. Харилцах дансанд 41.5 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна.Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр				
1	Эрүүл мэндийн дэмжих	1,453.70	1,453.70	0.00	100.00%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	56,932.30	54,246.04	-2,686.26	95.28%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,338.50	3,307.05	-31.45	99.06%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,453.70	1,453.70	0.00	100.00%
5	Нүүдлийн бүлэгт хамруулах	5,670.00	5,569.63	-100.37	98.23%
6	Боловсролын стандарт, сургалт	358,469.70	323,492.69	-34,977.01	90.24%
7	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	175,114.00	171,374.39	-3,739.61	97.86%
8	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	27,473.60	27,473.60	0.00	100.00%
	Дүн	629,905.50	588,370.80	-41,534.70	93.41%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй ба нэмэлт санхүүжилтийн харилцах дансны өмнөх оны үлдэгдэл 103.5 мянган төгрөгөөс 103.0 мянган төгрөгийг зарцуулж 500 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 106.1 сая төгрөгийн бараа материал, 0.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

сайжруулах үндсэн үйл ажиллагаа болон шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим Алтай аудит” ХХК-ны захирал бөгөөд аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Уужим Алтай Аудит” ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 448.9 сая төгрөгийн 2 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын 72.3 сая төгрөгийн 11 мөнгөн гүйлгээ, зарлагын 29.1 сая төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.0 сая төгрөгийн 2, авлага үүсгэсэн 12.6 сая төгрөгийн 2, өр үүсгэсэн 24.9 сая төгрөгийн 7, нийт 11 шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 25 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материалын дансанд оны эхэнд 13,305.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 55,448.0 мянган төгрөгийн хүнсний материалыг худалдан авч 40,674.2 мянган төгрөгийн хүнсний материалын зарцуулалт хийж оны эцэст 28,079.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Үүнээс 3,141 кг буюу 22,344.6 мянган төгрөгийн махны үлдэгдэлтэй байгаа нь бүтэн жилийн хэрэгцээний мах байгаа зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0		0		
Албан шаардлага	1	28,078.9	1	28,078.9	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	28,078.9	1	28,078.9	100%

Албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгахад махны нөөцийг их хэмжээгээр нөөцлөөгүй, аймгийн төвөөс 300 км алслагдсан сум тул цэцэрлэгийн хүүхдийн хоолны нөөцийг 3-аас 4 сараар нөөцлөх шаардлагатай байдагтай холбоотой хоол хүнсний материалын нөөц бүрдүүлж ажиллах зайлшгүй шаардлага тулгардаг байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг болон нярвын тайланг дэлгэрэнгүй шалгах, эд хөрөнгийн тооллогыг үзэх шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд нийт 55.0 сая төгрөгийн алдаа¹ илэрч, залруулга хийгдсэн.Үүнд:

Санхүүгийн байдлын тайланд нэмэлт санхүүжилтийн харилцахын үлдэгдлийг 0.1 сая төгрөгөөр илүү, тайлант оны үр дүнг 0.1 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 5.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 11.0 сая төгрөгийн бараа материалыг зөрүүтэй тайлагнасан, бараа үйлчилгээний зардлыг 0.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Мөнгөн гүйлгээний тайланд цалин болон нэмэгдэл урамшлын зардлыг 2.9 сая төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8.2 сая төгрөгөөр дутуу, гэрэл цахилгааны зардлыг 7.1 сая

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

төгрөгөөр илүү, түлш халаалтын зардлыг 6.8 сая төгрөгөөр дутуу, урсгал засварын зардлыг 0.3 сая төгрөгөөр дутуу, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.4 сая төгрөгөөр илүү, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус илүү, биет ба биет бус хөрөнгө худалдан авах 0.9 сая төгрөгийн зардлыг тайлагнаагүй байсныг залруулав.

Бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 11.0 сая төгрөгийн аж ахуйн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдаж авснаар тайлагнасныг залруулав.

Аудитаар 148.9 сая төгрөгийн зөрчил² илэрч 148.9 сая төгрөгийн албан шаардлага өгөв.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 148.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 72.3 сая төгрөгийн 11 мөнгөн гүйлгээ, зарлагын 29.1 сая төгрөгийн 4 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.0 сая төгрөгийн 2, авлага үүсгэсэн 12.6 сая төгрөгийн 2, өр үүсгэсэн 24.9 сая төгрөгийн 7, нийт 11 шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 25 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайланд	2	0.2			2	0.2	2	0.2				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Булган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

зөрүүтэй тайлагнасан.												
Санхүүгийн үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан.	3	16.8			3	16.8	3	16.8				
Мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй тайлагнасан.	7	27.0			7	27.0	7	27.0				
Бараа материалын тайланд зөрүүтэй тайлагнасан.	1	11.0			1	11.0	1	11.0				
Дүн	13	55.0			13	55.0	13	55.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах мэдээллийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 25 хувьтай байна.	1	148,907.3			1	148,907.3		
Дүн	1	148,907.3			1	148,907.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								